

санаагаар хүмүүжүүлэхийг зорьдог, тийм үзэл санааны үндэстэй сурах бичиг, гарын авлагыг л

сурагчиддаа бүтээн өгөхийг зорьдог билээ. Н. Алтанцэцэг

#### **А ХОДЖАЕВ. ЦИНСКАЯ ИМПЕРИЯ, ДЖУНГАРИЯ И ВОСТОЧНЫЙ ТУРКЕСТАН. М., 1979. 128 с.**

Хятад бус үндэстэн, түүний дотор Монгол, Төвд, Уйгур зэрэг хэзээнээс нааш биеэ даасан хэл, соёлтой, өөрийн гэсэн нутаг дэвсгэртэй, түүн дээрээ төр улсаа байгуулсаар ирсэн эртний соёлт үндэстнүүдийн түүхийг эдүгээ хятадын түүхчид их хан үндэстний дээрэнгүй үзлийн үүднээс зориуд гуйвуулж буй нь дэлхий дахинд илэрхий байна. Чухам ийм үед Зүүнгар, Дорнод Туркестаны түүх нийт дэвшилт түүхчид, Дорно дахиныг судлагч эрдэмтдийн анхаарлыг татаж буй нь санамсаргүй хэрэг биш юм.

Дорно дахины судлалын энэ салбарт юуны өмнө Орос, Зөвлөлтийн түүхчид цаглашгүй их хувь нэмэр оруулсан бөгөөд оруулсаар байна. Ялангуяа Хятадын түүх бичлэгт маоизмын хор нөлөөгөөр Чин улсын байлдан дагуулалтыг зөвтгөж Зүүнгар, Дорнод Туркестаныг угаасаа Хятадад харьяалагдаж байсан гэх буюу тийм учраас XIX зууны хоёр дугаар хагаст Чин улсаас Синьзянд явуулсан хүйс тэмтрэх, залхаан цээрлүүлэх үйл ажиллагааг цагаатгах болсон тавиад оноос хойш, хятадын түүхчдийн энэхүү түүх завхруулалтыг илчлэн няцаахад зөвлөлтийн нэрт эрдэмтэд, хятад судлаачид бүтээлээ зориулсаар байгаа бөгөөд ийм зохиолын нэг бол А.Ходжаевын «Цинская империя, Джунгария и Восточный Туркестан» юм.

Энэхүү ганц сэдэвт зохиол утга төгөлдөр томоохон хэмжээний оршил, Зүүнгар. Дорнод Туркестан дахь Чин улсын ноёрхол, түүний эсрэг хөдөлгөөн, Зүүнгарт (1871-1876) явуулсан залхаан цээрлүүлэх ажиллагаа, Дорнод Туркестаныг Чин улсын цэрэг эзэлсэн нь (1877-1878) гэх мэт дөрвөн бүлэг, тайлбар сэлт, номзүйн жагсаалтаас бүрдэж байна. Зохиолыг зөвлөлтийн Шинжлэх ухааны Академийн Дорнодахины судлалын хүрээлэнгээс эрхэлж ЗХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн С. Л. Тихвинский редакторлажээ.

Зохиогч тухайн сэдвээр Чин улсаас Зүүнгар, Дорнод Туркестанд явуулсан «залхаан цээрлүүлэх бодлогын» дүр төрхийг гарган харуулах гэсэн гол зорилгоо амжилттай биелүүлж XIX зууны хоёрдугаар хагаст хятад бус ард түмний талаар Чин улсын явуулж байсан их гүрний дээрэнгүй бодлогын талаар бидний мэд-

лэгийг өргөтгөж байна. «Нэг зэрлэгийг нөгөөгөөр нь даруулах» гэдэг хятадын хаадын уламжлалт зарчмыг манжийн хаад, ноёд Зүүнгар, Дорнод Туркестанд өргөн туршихаар барахгүй улам нарийсгаж «нэг зэрлэгийг нөгөөгөөр нь захируулах» бодлого явуулж орон нутгийн феодалуудад үе угсаа залгамжлах манжийн зэрэг хэргэм (ван, гүн бэйль, бэйс), угсаа үл залгамжлах үндэсний үүрэг тушаал (хаким-бек, ишик-ага-бек гэх мэт) хоёрыг хослуулан шагнаж тэднийг өөртөө татаж байсан нь өгүүлэн буй зохиолоос (22-р тал) илт харагдаж байна.

Чин улсын төрд үйлчилсэн эдгээр феодалууд, тэднийг гартаа атгаж буй жанжин, захирагч зэрэг Чин улсын их бага тушаалын түшмэл, тэдгээрийн хүнд суртлын аппаратын хажуугаар манжийн засгийн тугийн цэрэг, хот хамгаалах хятад цэрэг нийлж зөвхөн Тэнгэрийн тэтэгсэн хааны (1736-1796) үед 41 мянга гаруйд хүрч (23-р тал) байжээ. Манж-хятадын цэргийн хөсөг унаа, хүнс, хоол зэрэг хөрөнгө зардлын ихэнхи нь ард түмнээс хураах алба татвараас бүрдэх учир орон нутгийн хун амын амь зуултад хүндээр нөлөөлөхийн зэрэгцээ манжийн худалдаа-санхүүгийн харгис бодлогын уршгаар орон нутгийн үйлдвэр хоцрогдож, уурхай баялаг нь хорогдож байжээ. Түүнчилэн хас эрдэнийн чулуу, түүгээр хийсэн гоёлын зүйл, үнэт үслэг эд зэрэг Дорнод Туркестаны ховор нандин бүтээгдэхүүнд Чин улс онц эрхээ тогтоож (24-р тал) гадаад худалдаа их хятадын шунахай худалдаачдын гарт бүрмөсөн шилжсэн (25-р тал) зэрэг нь мөлжигч, мөлжигдөгсөдийн хоорондох зөрчлийг хурцатгаж, мөлжигдөгч ард олны дургүйцэл туйлдаа хүрч улмаар удаа дараагийн бослого хөдөлгөөнд хүргэжээ.

Чин улсын эрх баригчид хятад бус үндэстнийг хооронд нь дайсагнуулж нэгийг нөгөөгөөр нь даруулдаг сурамгай аргыг уламжлан авч үргэлжлүүлсэн нь Зүүнгарт 1864 онд өрнөсөн үндэсний чөлөөлөх хөдөлгөөнийг дарахад Улиастай жанжинд тушаал өгч баруун Монголоос удаа дараа олон мянган цэрэг дайчлан довтолгож босогчдод хядуулж байснаас (40-р тал) илэрхий байна. Гэвч манжийн цэргийн гол хэс-

гийг бүрэлдүүлж байсан хятад цэрэг болон орон нутагт манжийн дарлалыг гардан гүйцэтгэж байсан хятад худалдаачдад дургүйцсэн Зүүнгар, Дорнод Туркестаны лалын мөргөлтнүүд хятад, манж нарын эсрэг буюу тэдний нэрлэснээр «буруу номтны» эсрэг гэдэг лозунгийн дор Чин улсын ноёрхлын эсрэг тэмцэж байжээ. (35-р тал)

1870-аад оны үед Зүүнгарт шингэсэн цагаач хятадууд (газрын эзэд), манжийн цэргээс үлдэж хоцорсон хятад нараас бүрдсэн Туаньян хэмээх отрядууд энд тэнд байсан нь сүүлдээ Манж-Хятадын захиргааны заавраар босогчдын эсрэг тэмцэх томоохон хүч болон хувирч ялангуяа Зүүнгарын бослогын нөлөөг Шэньси, Тяньсу, Хөх нуурын дунганы босогчидтой нэгтгэхгүй байх, улмаар Зүүнгар, Дорнод Туркестаны уйгур, хятад мужийн дунган нарыг хооронд нь дайсагнуулахад чиглэгдэж байжээ. (56-р тал) Тэд бас Хами, Цитай, Жимс, Манас зэрэг олон районд дунганы босогчдыг залхаан цээрлүүлэхэд идэвхтэй оролцохын хамт Зүүнгарт Чин улсын цэргийн тариалан эрхлэн суурьшжээ. (58-р тал).

Зохиолын «1871—1876 онд Зүүнгарт Чин улсын явуулсан залхаан цээрлүүлэх ажиллагаа» хэмээх 111 бүлэгт 1862-1878 оны чөлөөлөх хөдөлгөөнөөр манжийн захиргааг халж байгуулагдсан Уйгурын Йэйтишар (Долоон хот) улсын талаар Ли Хунжан. Зо Зунтан зэрэг манжийн цэргийн генералууд өөр хоорондоо санал зөрж эцсийн бүлэгт Йэйтишарыг Чин улсын харьяанд түр боловч хүлээн зөвшөөрөх саналыг үл хэрэгсэн түүнийг шууд цэрэглэн дайлах төв засгийн шийдвэр гарсан. (68-72-р тал) Тэд Зүүнгар дахь хөдөлгөөнийг Монголд нэвтрэхээс ихээхэн болгоомжилсон ба гэтэл Тарвагатайн босогчдын 4 мянган хүнтэй отряд баруун Монголын гүнд нэвтэрч Улиастайг эзлэн улмаар Хүрээ, Ховдод хүртэл ойртсон (59-р тал) зэрэг түүхэн баримтуудыг иш татжээ.

А.Ходжаевын номын нэг онцлог нь түүнд хятад эх сурвалжууд өргөн ашиглаж, судалгаа, тооцоо нэлээд гаргасан нь харагдаж байна. Тухайлбал Тайваньд 1968 онд хэвлэгдсэн Зо Зунтаны зохиолын түүвэр, Бээжин, Шанхайд хэвлэгдсэн холбогдох зохиолуудыг нягталж үзсэнээр Манас хотын 2 сар үргэлжилсэн бүслэлтийн үед Зинь Шуны цэрэг босогчдыг бууж өгвөл амь өршөөнө гэж хуурч бэхлэлтээс гаргаж ирээд хөгшид, хүүхэд, эрэгтэй эмэгтэй нийт 3 мянга орчим дунганчуудыг нэг ч үлдээлгүй хядсан жишээг хятадын өөрийн нь баримт сэлтээр харуулсан нь (86-87-р тал) Чин улсын төр Зүүнгар, Дорнод Туркестаныг XVIII зууны дунд үеэр эзлэн авч,

хүйс тэмтрэх бодлого (Зүүнгарын хаант улсын хувьд) явуулсан бол XIX зууны хоёрдугаар хагаст түүнээс дутуугүй залхаан цээрлүүлэх экспедиц явуулж уйгур, дунганчуудын сэргээн босгосон улс төрийг нь устган мөхөөж, уг хязгаарт манж-хятадын ноёрхлыг дахин сэргээснийг гэрчлэх нотолгоо болж байна.

Зүүнгар, Дорнод Туркестаны 1864-1877 оны чөлөөлөх хөдөлгөөнийг Чин улсын засгийн газар 100 мянган цэргийн хүчээр харгислан дарж ноёрхлоо сэргээж байсныг зохиогч манжийн эзэн хаад, гоминьданы харгисчуудыг залган авч Синьзяны хятад бус ард түмнийг хүчээр уусгах бодлого (106-р тал) явуулж байгаа хятадын одоогийн эрх баригчдын их гүрний жанжлах байр суурьтай уялдуулан авч үзэхэд цаг үеийн чухал сэдэв болж байна гэж оновчтой дүгнэснээр барахгүй бидний бодлоор нэг хоёр зүйлийг тодруулж дурдахад илүүдэхгүй байсан болов уу. Юу гэвэл нэгдүгээрт, XIX-ны II хагаст Зүүнгар, Дорнод Туркестанд явуулсан Чин улсын колоничлолын бодлогыг зохиогч «залхаан цээрлүүлэх бодлого» гэж томъёолсон газар их байна. Гэтэл Зо Зунтаны «залхаан цээрлүүлэх аян дайн» (тэд өөрсдөө «баруун зүгт хийсэн аян дайн» гэж нэрлэдэг тухай А. Ходжаевын номд ч бий) бол зохиогчийн номынхоо давхар гарчигт тусгасаны адил «XIX-ны II хагас дахь Чин улсын үеийн хятадын колоничлох бодлого»-ын тодорхой илрэл, нөгөө талаар Чин улсын арми Зүүнгар, Дорнод Туркестаныг колоничлоод стратегийн энэ чухал районыг цаашид дундад Ази, Казакстанд нэвтрэх түшиц газар болгох хэзээний санаархлаа тухайн үед ч орхиогүй гэдгийг тус тус цохон тэмдэглэж өгүүштэй байжээ.

Түүнчилэн зохиолд бослогын удирдагчид Якуб-бек, Бай яньху зэрэг түүхт хүмүүсийн үйл ажиллагаа, тэднээс манжийн булаан эзлэгчдийн эсрэг явуулсан тэмцлийг олон тооны тодорхой баримтаар харуулсан боловч их төлөв тоочих хэлбэрээр авсан учир зарим үед тэдгээр ээдрээтэй нарийн үйл явдлын зангилааг тайлахад хялбаргүй тал харагдаж байна. (53—57-р тал).

Гэвч А. Ходжаевын зохиол олон янзын эх сурвалжийг чадамгай ашигласан үндсэн дээр Чин улсын колоничлолын маш эмзэг бөгөөд бага судлагдсан сэдвийг хөндсөн учир тэр талын судалгааг цаашид гүнзгийрүүлэхэд үнэтэй чухал эхлэлтээр зогсохгүй хятадын түүх бичлэгийн зуршил болсон өрөөсгөл хандлагад болон түүнийг улируулан давтаж улам завхруулж буй хятадын өнөөгийн түүхчдэд няцаалт болсон шинэ, дорвитой бүтээл болжээ.

## Э. Пунцаг